



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/213.

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 7 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 479 дэх хэсэг, 2017 оны А/422 дугаар захирамжийн хавсралтын 25 дахь хэсэг, 2016 оны А/64 дүгээр захирамжийн 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210594

Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 16 ны өдрийн
 А/13 дугаар захирамжийн хэвсгалт

№	Өмчлөгчийн			Өмнөх захирамжийн		Өмнөх газрын		Газрын			
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо дугаар	Холбогдох хэсгийн дугаар	Байршил	Хэмжээ /м2/	Байршил	Хэмжээ /м2/	Байршил	Үнэ /төгрөг/
1	Сайнбилэг	Доржсүрэн	3384072611			Мандал 1-24	600	Партизан 1-101	892		1338000
2	Дүүшатар	Отгонбаяр	ЗИ97071411	2017.11.27 А/422	25	Говь 17-1784	900	Буянт 7-768	700		1050000
3	Лханаа	Отгонцэцэг	ЦГ68082903	2016.02.19 А/64	2	Боржигон 7-1	750	Боржигон 13-1301	772		1544000
4	Энэбиш	Жигжид	ЗЮ77092071			Боржигон 21-2	909	Боржигон 23-2303	1023		2046000
5	Ёндон	Сугар	ЗЮ52110701			Айраг 10-36	1249	Айраг 8-878	1464		2928000
6	Маам	Отгонжаргал	ЗИ83011308			Зам анги 1-8	500	Нарлаг 10-1000а	695		1042500
7	Шаалай	Улаанбаатар	ЗЮ71031114	2005.12.08 319	479	Айраг 7-3	450	Айраг 6-605	480		960000